


2. Зөвлөмж, гарын авлага

Бага ангийн бүлэг бүрийн номын санд каталоогоос ном захиалах заавар

Аймгийн төв ба сумын сургуулийн бага ангийн бүлэг бүрт зориулан Хүүхдийн номын каталогийг боловсруулсан ба каталоогоос бага ангийн багш нар номын захиалгаа хамтарч хийгээд, сургууль захиалгыг нь нэгтгэн БСШУСЯ-ны “Боловсролын салбарын мэдээллийн систем (БСМС)”-ээр дамжуулан онлайнаар ирүүлнэ.

БСМС ДЭЭРХ “НОМ ЗАХИАЛАХ МАЯГТ” ЦОНХНЫ ТАНИЛЦУУЛГА

<http://www.esis.edu.mn> сайтаар өөрийн сургуулийн эрхээр ороод Асуулгын удирдлага модулийн “Ном захиалах маягт” гэсэн цонхыг нээнэ.



НОМЫН ЗАХИАЛГА ХИЙХ ДАРААЛАЛ

1-Р АЛХАМ: КАТАЛОГООС НОМ СОНГОХ

“Ном захиалах маягт” хуудасны баруун дээд талын цонхноос **НОМЫН КАТАЛОГЫГ ТАТАЖ**, бага ангийн бүх багш нарт файл хэлбэрээр өгнө.



Багш нар ном бүрийн мэдээлэлтэй сайтар танилцаад, сонгосон номын дугаар болон нэрийг захиалга нэгтгэх хүнд бичиж өгнө.

2-Р АЛХАМ: БҮЛЭГ БҮРИЙН ЗАХИАЛАХ НОМЫГ НЭГТГЭХ

Сургууль нь захиалга нэгтгэх хүнийг томилж, цонхны баруун дээд талд байгаа **ЗАХИАЛГА НЭГТГЭХ ФАЙЛЫГ** татаж бүлэг бүрийн захиалсан номын тоог оруулна.




“Захиалга нэгтгэх файл”-ыг(excel) хэрхэн бөглөх вэ?

- ✓ Зааврыг уншина. I-V анги тус бүрээр нэрлэсэн хуудас бүр дээр зөвхөн шараар тодруулсан хэсэгт дараах байдлаар захиалгаа оруулна.
 - Номын дугаар гэсэн хэсэгт сонгосон номын 4 оронтой дугаарыг бичихэд номын нэр болон нэгжийн үнэ автоматаар гарч ирнэ.
 - Тухайн дугаартай номноос захиалах тоог бүлэг тус бүрээр оруулна.
 - Нэг бүлэг нэг номноос 5-с дээш ширхгийг захиалахгүй болохыг анхаарна уу.

Жишээ нь: I анги гэсэн хуудсанд **1002 дугаартай “Аавын тоглоом” нэртэй ном**, 1-р ангийн 7 бүлэг тус бүр 1-2 ширхэг захиалсан тоог оруулахад нийт тус ном 12 ширхэг 50,160 төгрөг гэж автоматаар бодогдоно.

3-Р АЛХАМ: “БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ”-ЫН НОМ ЗАХИАЛАХ МАЯГТАНД ЗАХИАЛГАА ШИВЭХ



БСМС-ын <http://www.esis.edu.mn> сайтын “Ном захиалах маягт” цонхонд СУРГУУЛИЙН НЭГТГЭЛ хуудаснаас номын **ЗАХИАЛГЫН ТООГ** нэг бүрчлэн гараар шивж оруулна.

Ном захиалах маягт (тоогоор)

А. Алхын тоо ба сумын сургуулийн бага ангийн номын санц каталогоос ном захиалах маягт

Холбоо барих хүн:	Barbald	Нийт санхүүжилтийн эрх (төгрөг):	16,758,000.00
Утасны дугаар:	99554411	Төсөв 1-р анги:	1,837,500.00
Нийт санхүүжилтийн эрх (төгрөг):	16,758,000.00	Төсөв 2-р анги:	2,940,000.00
Захиалсан номын нийт тоо:	919	Төсөв 3-р анги:	3,430,000.00
Захиалсан номын нийт үнэ (төгрөг):	16,599,660.00	Төсөв 4-р анги:	3,920,000.00
Зөрүү ():	158,340.00	Төсөв 5-р анги:	4,630,500.00

№	Номын дугаар	Номын нэр	Анг	Номын нэгжийн үнэ (төгрөгөөр)	Хэдэн хуудыг захиалах /шигсэл/	Дүн
1	1001	6-н настай хүүхдийн баруун тэрхийг хөгжүүлэх	1	5,800.00	10	58,000.00
2	1002	Алтан тоглоом	1	4,180.00	12	50,160.00
3	1003	Алаг эрхэн тасла	1	18,000.00	13	234,000.00
4	1004	Аллага гүнж	1	3,800.00	19	57,000.00
5	1005	Алтан үст ба 3-н баагай үстэй унших ном	1	2,800.00	25	70,000.00
6	1006	Алтан үст охин ба гурван баагай	1	5,900.00	15	88,500.00

- ✓ **ХАДГАЛАХ** товчийг дарснаар нийлбэр дүн бодогдоно.
- ✓ Номын захиалгаа зөв оруулсан бол нийлбэр дүн болон зөрүү дүн СУРГУУЛИЙН НЭГТГЭЛ хуудасны дүнтэй тохирч байх ёстой.
- ✓ **ИЛГЭЭХ** товч дарснаар захиалга хийгдэнэ.
- ✓ Илгээсэний дараа **Цуцлах** товч үүсэх засвар оруулах шаардлагатай үед ашиглана.

4-Р АЛХАМ: “ЗАХИАЛГА НЭГТГЭХ ФАЙЛ”-ЫГ (EXCEL) И-МЭЙЛТЭЭР ЯВУУЛАХ

- ✓ “Боловсролын салбарын мэдээллийн систем”-д захиалгаа оруулахаас гадна "Номын захиалга нэгтгэх файл"-даа **нэр** өгөөд nom.2018sb@gmail.com хаяг руу и-мэйлээр илгээнэ.

Жишээ нь: Архангай_Хотонт гэж аймаг сум, сургуулийнхаа нэрээр нэрлэнэ.

- ✓ Захиалгаа 2018 оны 9-р сарын 28-ны дотор дээрх 2 хувилбараар илгээнэ.

АСУУЛТ БАЙВАЛ ХОЛБОГДОХ УТАС: 70001220 (ажлын цагаар)

ГАР УТАС: 99055727